Суурь боловсролын II дамжааны танилцах дадлагын зарим үр дүн

М.Үзмээ[1], С.Нармандах[1], М.Энхтөгөлдөр[2], О.Болормаа[1], С.Оюунцэцэг[1]

[1]АШУҮИС, Био-Анагаахын сургууль, Харилцааны ур чадварын тэнхим
[2]АШУҮИС, НЭМС, Эпидемиологи, биостатистикийн тэнхим
Цахим шуудан: uzmee@mnums.edu.mn, Утас:90091108

Түлхүүр үг:

Сэтгэл ханамж
Сургалтын орчин
Чадамж
Хэрэгцээ

Товч утга:

Үндэслэл: Мэдлэгийг шинжлэх ухаанд үндэслэн хэрэглээ болгох замаар эмнэлгийн орчинд оюутны мэдлэг, чадвар, хандлагыг цогцоор нь дадлагажуулах, эмнэлэгт ажиллах анхны алхам сэтгэдэл төрүүлэх, гардан ажилбар хийж гүйцэтгэх ур чадварын талаарх цогц чадамжийг анагаахын суурь сургалтын түвшинд үзүүлэх, үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ үзүүлэх бүрт харилцаа тогтоож, үйлдэл бүрийг чин сэтгэлээсээ хариуцлагатай гүйцэтгэж чаддаг, мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэн төлөвшүүлэх нь чухал байна[1]. Танилцах дадлага нь тэнхимийн дадлага удирдах гэрээт багш нартай нягт уялдаа холбоотой хийгддэг тул тэдний санал, тулгамдсан асуудал, зөвлөмжийг сонсох, сэтгэл ханамжийг судлах, хөтөлбөрийн агуулга, арга зүйд өөрчлөлт хийх хэрэгцээ нэмэгдсээр байна. Цаашид мэргэжлийн хөтөлбөрт тусгагдсан танилцах дадлагыг (АСБД 96 цаг) болон (ЭМСБД 48 цаг)-аар хийж буй оюутнуудын хувьд хэрхэн үр дүнтэй, сэтгэл ханамжтай байгааг судлаж, танилцах дадлагыг улам боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна. **Зорилго:** Суурь боловсролын II дамжааны танилцах дадлага хичээлийн үр дүнг судлах. **Арга, аргачлал:** Судалгааг тоон болон чанарын судалгааны арга, эмнэлэгт суурилсан ажиглалтын загварыг ашиглан гүйцэтгэв. Судалгаанд төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газрын тушаалаар баталгаажсан танилцах дадлага удирдах 16 эмнэлгийн дадлага удирдах 21 гэрээт багш нараас 8 гэрээт багшаас судалгаанд оролцох зөвшөөрлийг авч, цахим (google form) ашиглан хаалттай 5, нээлттэй 2 асуумжаар, эмнэлэгт дадлага хийсэн анагаахын суурь болон эрүүл мэндийн суурь боловсролын II дамжааны 162 оюутнуудаас цахим (google form) хаалттай 7, нээлттэй 2 асуумжаар тус тус судалгаа авлаа. Судалгаанд оролцогч нараас сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор Ликертийн таван онооны хэмжүүрийг ашиглан сэтгэл ханамжийн үзүүлэлт буюу өгөгдөл бүрийг 1-5 оноогоор (1- сэтгэл ханамж маш муу, 5 - сэтгэл ханамж маш сайн) үнэлсэн. Мөн дадлага удирдсан гэрээт багш нарын төлөөлөл 8 гэрээт багштай ярилцлагын чиг асуулттай хуудас ашиглан, ганцаарчилсан ярилцлага хийлээ. **Үр дүн:** Тэнхимийн гэрээт багш нарын 37.5%-д нь эмнэлэгт хариуцсан ажлын зэрэгцээ оюутан удирдан дадлагажуулах нь дунд зэргийн хүндрэлтэй, 25%-д нь хүндрэл бага, харин 37,5% нь хүндрэл маш бага гэж хариулсан байна. Дадлага хийсэн оюутнуудын анхны мэдлэг, чадварыг гэрээт багш нарын 60% нь дунд зэрэг, 40% нь сайн гэж үнэлсэн байна. Оюутнуудын хувьд тухайн эмнэлгийн эмч, сувилагчийн харилцаа хандлагад хамгийн их сэтгэл ханамжтай байсан буюу 82.4% нь сайн болон маш сайн гэж үнэлсэн байна. Тухайн эмнэлгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн харилцаа хандлагад оюутнуудын 75.5% нь сайн болон маш сайн гэж хариулсан байна. Мөн тухайн эмнэлгийн бусад эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагад 75.5% нь сайн болон маш сайн гэж хариулсан байна. Оюутнуудын маань 81.7% нь танилцах дадлагыг үр дүнтэй байсан гэж дүгнэжээ. **Дүгнэлт:** 1. Танилцах дадлага нь анагаахын болон эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын эмнэлэгт хийх дадлагын анхны гараа буюу оюутнууд хичээлийн агуулыг өөрөөр хэлбэл мэдлэгийг хэрэглэх, ашиглах, өөрийн болгох боломж олгодог чухал дадлага юм. Гэвч эмнэлгүүдэд оюутанд зориулсан сургалтын өрөө, хувцас солих өрөө, локерны асуудал шийдэгдээгүй байна. 2. Оюутны тоо хэт их, зарим оюутнуудыг хол эмнэлгүүдэд дадлагад гаргаж байгаа нь оюутнуудад хүндрэлтэй, дадлага удирдах гэрээт багш нар авч байгаа урамшуулалдаа сэтгэл дундуур, оюутны тоо их, ачаалал их зэрэг асуудлуудтай тулгарч байна.

Үндэслэл: Эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн бэлтгэх суурь ур чадвар болох харилцааны ур чадварт суурилж, мэргэжлийн суурь ур чадвар хичээлийн лекц, дадлагын хичээлээр олгосон мэдлэг, чадвар, хандлагыг цогцоор нь эзэмшүүлэхэд дадлагын үнэ цэнэ оршино. Эмнэлгийн төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцох нь оюутнуудад мэргэжлээ ойлгох, мэргэжилдээ дурлах зэрэг ач холбогдолтой[2]. Эмнэлэгт ялангуяа үйлчлүүлэгчидтэй шууд харилцах нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойлгох, эмч, эмнэлгийн мэргэжилтэнээр бахархах сэдлийг төрүүлдэг[3]. Оюутнууд эмнэлэгт дадлагажих явцад үүсэх асуудлыг зөв тодорхойлох, цагийн менежмент, хувь хүний биеэ авч явах соёл (этикет) зарим асуудлыг багшийн удирдлаган доор шийдвэрлэх, багаар ажиллах, эргэцүүлэн сэтгэх зөөлөн чадваруудыг дадал болгох хэрэгцээтэй байна. Танилцах дадлагын зорилго нь аль ч салбарт ажиллах мэргэжилтэн нь хүнийг энэрэн хайрлах, хүмүүнлэг ёсыг сэтгэл зүрхэндээ нэвт шингээсэн, хүн хүнтэйгээ ойлголцож, хамтран ажиллаж, амьдрах, нийгэмд биеэ зөв авч явах ёсзүйг өндөр түвшинд эзэмшсэн, өөрийн эрүүл мэнд, гэр бүлийн өмнө хариуцлага хүлээсэн, хүний зовлон шаналгааг ойлгож мэдэрдэг, сэтгэлээсээ хуваалцаж чаддаг мэргэжилтэнг төлөвшүүлж, дэмжлэг үзүүлдэг чухал ач холбогдолтой.

Дадлагын явцад I, II, III шатлал, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн орчинтой танилцах, оюутны бие даан суралцах чадварыг дээшлүүлэх, мэдлэгийг дадал болгох, танхимийн сургалтаас олж авсан мэдлэг, чадвар хандлагаа мэдлэг бүтээх онолын дагуу санах, ойлгох, сэргээх, хэрэглэх задлан шинжлэх, үнэлэх, бүтээлчээр хандах, аливаа зүйлийн цаад мөн чанарыг олох чадварт суралцах, үйлчлүүлэгчтэй харилцаа тогтоох, бүтээлч чадвар, нягт нямбай чанар, ачаалал даах чадваруудыг зэрэг эзэмшүүлдэг. Танилцах дадлага нь оюутан, мэргэжилтний хооронд мэдлэг, чадвар, хандлагын талаарх мэдлэг мэдээлэлийг солилцохамьдралын сургалт, сайн мэргэжилтэн болоход тусалдагаараа онцлог юм. Эмнэлгийн орчинд гардан ажилбарыг анагаахын суурь сургалтын түвшинд үйлчлүүлэгчдэд үзүүлэх тохиодолд харилцаа тогтоон, үйлдэл бүрийг чин сэтгэлээсээ хариуцлагатай гүйцэтгэдэг мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэн төлөвшүүлнэ. Оюутан бүр эмнэлэгт дараах үе шаттайгаар дадлагыг хийж гүйцэтгэдэг:

I. Дадлага удирдсан багш, сургалтын бааз эмнэлгийн гэрээт багш, хэсгийн оюутан бүрийн хооронд гурвалсан гэрээ байгуулна.
II. Дадлага удирдах багш, дадлага хийх оюутны эрх үүрэгтэй танилцана
III. Дадлага хариуцсан координатар багш, дадлага удирдах гэрээт багшид дадлагын хуваарийг дадлага эхлэхээс 14 хоногийн өмнө хүргүүлнэ.
IV. Дадлага хариуцсан координатор багш, дадлага удирдах гэрээт багшийн удирлагад оюутан дадлагыг хийж гүйцэтгэнэ.
V. Дадлага удирдах гэрээт багш оюутан бүрийг дагалдуулан тасаг, нэгжид цагийн хуваарийн дагуу хуваарилж, дадлагад гаргана.

Дадлага удирдсан багш, сургалтын бааз эмнэлгийн гэрээт багш, хэсгийн оюутан нар гэрээ байгуулж, эрх, үүрэгтэйгээ сайн танилцсанаар гэрээт эмнэлэг, үйлчлүүлэгч, оюутан, багшийн хооронд үл ойлголцол гарахаас сэргийлдэг. Дадлагын явцад оюутан үйлчлүүлэгчид өөрийгөө тодорхой танилцуулах нь үйлчлүүлэгчийн үл итгэх, үйлчилгээ авахаас татгалзах зэрэг бэрхшээлүүдээс сэргийлдэг байна[4].

2022-2023 оны хичээлийн жилд Анагаахын суурь болон эрүүл мэндийн суурь боловсролын II дамжааны нийт 887 оюутны танилцах дадлагыг 16 эмнэлгийн 21 дадлага удирдах гэрээт багш нартай хамтран зохион байгуулсан. Анагаахын суурь боловсролын дамжааны оюутнууд 96 цаг, эрүүл мэндийн суурь боловсрлын дамжааны оюутнууд 48 цагийн дадлага хийдэг бөгөөд дадлагын төгсгөлд оюутнууд эмч, эмнэлгийн мэргэжилтэний үнэ цэнэ, мэргэжилтэнүүдийн хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдлэгтэй болж, үйлчлүүлэгчтэй харилцах, мэндлэх, хүндлэх, амин үзүүлэлт хэмжих, хянах, аюулгүй тарилга хийх зарчимд суралцаж, багаар ажиллах, цаг баримтлах, аливаад чин сэтгэлээсээ хандах зэрэг зөөлөн чадварт суралцдаг байна. Танилцах дадлага нь тэнхимийн дадлага удирдах гэрээт багш нартай нягт уялдаа холбоотой хийгддэг тул тэдний санал, тулгамдсан асуудал, зөвлөмжийг сонсох, сэтгэл ханамжийг судлах, хөтөлбөрийн агуулга, арга зүйд өөрчлөлт хийх хэрэгцээ нэмэгдсээр байна. Цаашид мэргэжлийн хөтөлбөрт тусгагдсан танилцах дадлагыг (АСБД 96 цаг) болон (ЭМСБД 48 цаг)-аар хийж буй оюутнуудын хувьд хэрхэн үр дүнтэй, сэтгэл ханамжтай байгааг судлаж, танилцах дадлагыг улам боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн технологи, эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүдийн стандарт MNS 4621:2008, Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж ирсэн[5,6]. 2023 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой Монгол улсын стандарт болох MNS 7014:2023 батлагдсанаар эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж буй үйлчилгээ эрхлэгч байгууллагын ажилтанд болон ажлын байранд тавих ерөнхий шаардлагыг тогтоосон. Энэ стандартыг эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчид, анагаахын оюутнууд хэвшүүлэх шаардлагатай байна[7].

Зорилго: Суурь боловсролын II дамжааны танилцах дадлага хичээлийн үр дүнг судлах.

Зорилт:

1. Дадлага удирдах гэрээт багш нарын сэтгэл ханамжийг судлах
2. II,III шатлал хувийн эмнэлгүүдэд дадлага хийж буй оюутнуудын сэтгэл ханамж, үр дүнг харьцуулан судлах

Арга, аргачал: Судалгааг тоон болон чанарын судалгааны арга, эмнэлэгт суурилсан ажиглалтын загварыг ашиглан гүйцэтгэв. Судалгаанд төгсөлтийн

өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газрын тушаалаар баталгаажсан танилцах дадлага удирдах 16 эмнэлгийн дадлага удирдах 21 гэрээт багш нараас 8 гэрээт багшаас судалгаанд оролцох зөвшөөрлийг авч, цахим (google form) ашиглан хаалттай 5, нээлттэй 2 асуумжаар, эмнэлэгт дадлага хийсэн анагаахын суурь болон эрүүл мэндийн суурь боловсролын II дамжааны 162 оюутнуудаас цахим (google form) хаалттай 7, нээлттэй 2 асуумжаар тус тус судалгаа авлаа. Судалгаанд оролцогч нараас сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор Ликертийн таван онооны хэмжүүрийг ашиглан сэтгэл ханамжийн үзүүлэлт буюу өгөгдөл бүрийг 1-5 оноогоор (1-сэтгэл ханамж маш муу, 5-сэтгэл ханамж маш сайн) үнэлсэн. Мөн дадлага удирдсан гэрээт багш нарын төлөөлөл 8 гэрээт багштай ярилцлагын чиг асуулттай хуудас ашиглан, ганцаарчилсан ярилцлага хийлээ.

Үр дүн: Судалгаанд оролцсон оюутнуудын 86.5% (n=140) нь анагаахын суурь боловсролын дамжаа, 13.5% (n=22) нь эрүүл мэндийн суурь боловсролын дамжаанд суралцсан байна. Дадлага удирдах гэрээт багш нарын 37.5% (n=3)-д нь эмнэлэгт хариуцсан ажлын зэрэгцээ оюутан удирдан дадлагажуулах нь дунд зэргийн хүндрэлтэй, 25% (n=2)-д нь хүндрэл бага, харин 37.5% (n=3) нь хүндрэл маш бага гэж хариулсан байна. Дадлага хийсэн оюутнуудын дадлагад гарахаас өмнөх мэдлэг, чадварыг гэрээт багш нарын 60% нь дунд зэрэг, 40% нь сайн гэж үнэлсэн байна. Харин оюутнуудын биеэ авч явах соёл, харилцаа хандлагыг 33.3% нь дунд зэрэг, 66.7% нь сайн болон маш сайн гэж дүгнэжээ.

Гэрээт багш нарын 73.3% нь танилцах дадлагыг үр дүнтэй, 26.7% нь дунд зэргийн гэж үнэлсэн байна. Судалгаанд оролцогч гэрээт багш нарын 53.3% нь дадлага удирдсан цагийн хөлсөнд сэтгэл ханамж дундмаг, 20% нь сэтгэл ханамжгүй, 26.7% нь сэтгэл ханамжтай байдаг гэж хариулжээ. Ярилцлагаар гэрээт багш нар эмнэлэгт оюутнуудын хувцас солих өрөө, локер дутмаг, төлөвлөсөн дадлагын хуваарийг өөрчлөх эсвэл өөр хичээлтэй давхцах зэрэг нь дадлагад бага зэрэг хүндрэл учруулдаг гэж хариулсан байна. Оюутнуудын хувцас солих асуудлыг шийдвэрлэх, дадлагын хуваарийг нарийвчлан гаргах, мөн оюутнуудын эзэмшиж буй мэргэжилдээ дуртай болох тал дээр анхаарах, цаашид дадлагыг улам боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэв.

Оюутнуудын танилцах дадлагыг улсын болон хувийн эмнэлгүүд таатай, эерэгээр хүлээн авдаг. Оюутны тооноос шалтгаалан улирал бүр дадлага хийх эмнэлгүүдийн тоо болон дадлага удирдах гэрээт багш нарын тоо харилцан адилгүй байдаг. Оюутнуудыг тухайн эмнэлэгт хэт олноор бус цөөн тоогоор, дадлагыг чанартай хийлгэх тал дээр тэнхим анхаарч гэрээт багш нартай хамтран ажилладаг. Танилцах дадлага хийх оюутнуудыг хүлээн авч, хамтран ажилладаг гэрээт эмнэлгүүдийг хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Давхардсан тоогоор танилцах дадлага зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллагууд

Эмнэлгийн нэр	n (%)
Дүүргийн нэгдсэн эмнэлэг (Хан уул, Сонгинохайрхан)	48 (29.6)
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	47 (29.01)
Монгол японы эмнэлэг	21 (12.9)
Хавдар судлалын үндэсний төв	17 (10.5)
Хувийн эмнэлэг	13 (8.02)
Улсын гуравдугаар төв эмнэлэг	9 (5.6)
Гэмтэл согог судлалын үндэсний төв	5 (3.1)
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	2 (1.2)

Судалгаанд оролцсон оюутнуудын тухайн эмнэлгийн гэрээт багш, эмч, сувилагчийн харилцаа хандлагад хамгийн их сэтгэл ханамжтай буюу 82.4% нь сайн болон маш сайн гэж үнэлсэн байна. Тухайн эмнэлгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн харилцаа хандлагад оюутнуудын 75.5% нь сайн болон маш сайн гэж хариулсан байна. Оюутнууд дадлага хийсэн эмнэлгийн бусад эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагад 75.5% нь сайн болон маш сайн гэж, оюутнуудын маань 81.7% нь танилцах дадлагыг үр дүнтэй байсан гэж дүгнэжээ. Харин эмнэлэгт танилцах дадлагыг хийх явцад тулгарсан бэрхшээлээс оюутнууд: зарим эмнэлэг арай хол, хувцас солих, амрах өрөө байхгүй, зарим мэргэжилтнүүд загинах, уурлах тохиолдол гарч байсан, танилцах дадлагыг улам сайжруулах тал дээр оюутнуудад хувцасны шүүгээ гаргаж өгөх, дадлагыг зөвхөн 1 тасагт биш өөр олон тасгуудад ээлжлэн хийлгэх, дадлагын явцад оюутнуудыг 1 удаагийн маск, бээлийгээр хангах зэрэг саналуудыг дурьдсан байна.

Судалгаанд оролцогч оюутнуудаас сэтгэл ханамжийг үнэлэхэд оюутнууд танилцах дадлагын талаар сэтгэл ханамжтай, дадлага үр дүнтэй байсан гэж дүгнэжээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Оюутнуудын танилцах дадлагын талаарх сэтгэл ханамжийг үнэлсэн байдал

Асуултууд	Тоо	Дундаж ± SD
Тухайн эмнэлгийн гэрээт багш, эмч, сувилагчийн харилцаа хандлагад хэр сэтгэл ханамжтай байсан вэ	162	4.41±0.58
Тухайн эмнэлгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн харилцаа хандлагад хэр сэтгэл ханамжтай байсан вэ	162	3.91±0.69
Тухайн эмнэлгийн бусад эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагад хэр сэтгэл ханамжтай байсан вэ	162	3.77±0.85
Тухайн эмнэлэгт дадлага хийхэд хэр тохиромжтой байсан бэ	162	4.04±0.81
Эмнэлэгт дадлага хийхэд ямар үр дүнтэй байсан бэ	162	4.19±0.74

Оюутнуудын сэтгэл ханамжийг аль эмнэлэгт дадлага хийснээр буюу II, III дугаар шатлалын эмнэлэг болон хувийн эмнэлэгт хийснээр нь харьцуулан үзэхэд II дугаар шатлалын буюу дүүргийн нэгдсэн эмнэлэгт нийт 48 оюутан, III дугаар шатлалын эмнэлэгт нийт 101 оюутан, хувийн эмнэлэгт нийт 13 оюутан дадлага хийсэн байна.

Танилцах дадлагыг аль эмнэлэгт хийсэнтэй хамааралтай оюутнуудын сэтгэл ханамжийг үнэлэхэд статистикийн ач холбогдолтой ($p<0.001$) буюу оюутны тухайн эмнэлгийн гэрээт багш, эмч, сувилагчийн харилцаа, хандлагад сэтгэл ханамжтай байх нь дадлага хийсэн эмнэлгээс шалтгаалан өөр өөр байсан бол бусад асуултуудын хувьд ялгаа ажиглагдсангүй (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Оюутнуудын танилцах дадлагын талаарх сэтгэл ханамжийн асуулт бүрийг эмнэлгээр үнэлсэн байдал

Асуултууд	II шатлал	III шатлал	Хувийн эмнэлэг	P утга
Тухайн эмнэлгийн гэрээт багш, эмч, сувилагчийн харилцаа хандлагад хэр сэтгэл ханамжтай байсан вэ	3.77	4.36	4.15	<0.001
Тухайн эмнэлгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн харилцаа хандлагад хэр сэтгэл ханамжтай байсан вэ	3.81	3.96	4.00	0.735
Тухайн эмнэлгийн бусад эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагад хэр сэтгэл ханамжтай байсан вэ	3.56	3.87	3.92	0.139
Тухайн эмнэлэгт дадлага хийхэд хэр тохиромжтой байсан бэ	3.89	4.14	3.69	0.221
Эмнэлэгт дадлага хийхэд ямар үр дүнтэй байсан бэ	4.18	4.20	3.92	0.214

Гуравдугаар шатлалын болон хувийн эмнэлүүдэд дадлага хийсэн оюутнуудын сэтгэл ханамж нь хоёрдугаар шатлал буюу дүүргийн нэгдсэн эмнэлэгт дадлага хийсэн оюутнуудаас харьцангуй өндөр боловч статистикийн хувьд ялгаагүй байна ($p=0.089$) (Хүснэгт 4) .

Хүснэгт 4. Оюутнуудын танилцах дадлагын талаархерөнхий сэтгэл ханамжийг эмнэлгээр үнэлсэн байдал

Асуултууд	n (%)	Дундаж ± SD	P утга
II дугаар шатлалын эмнэлэг	48 (29.6)	3.85±0.23	0.089
III дугаар шатлалын эмнэлэг	101 (62.3)	4.11±0.19	
Хувийн эмнэлэг	13 (8)	3.94±0.17	

Хэлцэмж: Судлаач Dickman N (2023) нар нийт анагаахын 710 оюутнуудын дунд эмнэлэгт хийсэн эмнэлзүйн тойролтын талаарх сэтгэл ханамжийг судлахад сэтгэл ханамжийн дундаж нь 4.11±1.06 гэж тодорхойлсон нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна[8]. Судлаач AkbariRad M (2023) нарын судалгаанд анагаахын 118 оюутнуудын 88.9% нь эмнэлэгт хийсэн дадлага нь илүү ихэд суралцах сэдлийг төрүүлсэн гэсэн нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна[9].

Судлаач Theobald M (2021) нар сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд дүрэм журмын хязгаарлалт, баримт бичгийн ачаалал зэрэг олон хүчин зүйлс нь оюутнуудын эмнэлзүйн тусламж үйлчилгээнд бодитой хувь нэмэр оруулах боломжийг хязгаарлаж, оюутнуудын хийх ажлуудыг хумисан, гэвч сүүлийн үед зарим системийн өөрчлөлт нь оюутнуудад дахин эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх багийн гишүүд болох шинэ боломжийг бий болгож байгаа нь өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээ сайжирч, оюутнуудад илүү сайн суралцах боломж бүрдэх юм гэсэн байна[10]. Өнөөдөр сурган хүмүүжүүлэгч нар оюутнуудын эмнэлэгт гарах боломж буюу идэвхитэй сургалтыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн байна[11]. Эдгээр нь бидний судалгаанд оролцсон гэрээт багш нараас авсан судалгааны үр дүнд 73.3% нь танилцах дадлагыг үр дүнтэй гэж үнэлсэнтэй дүйж байна. Судлаач Alsiö Å (2019) нар судалгаандаа эмнэлэгт анагаахын оюутны сургалтыг явуулсанаар тэнд ажиллагсадын дунд дахин суралцах сэдлийг төрүүлж байна, мөн эрүүл мэндийн мэргэжилтэнүүдийн дунд анагаахын боловсролын талаарх хандлага, ойлголтыг хэлэлцэх нь анагаахын сургалтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгоход дөхөм болж байгаа талаар дурьдсан нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна[12].

Дүгнэлт:

1. Танилцах дадлага нь анагаахын болон эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын эмнэлэгт хийх дадлагын анхны гараа буюу оюутнууд хичээлийн агуулыг өөрөөр хэлбэл мэдлэгийг хэрэглэх, ашиглах, өөрийн болгох боломж олгодог чухал дадлага юм. Гэвч эмнэлгүүдэд оюутанд зориулсан сургалтын өрөө, хувцас солих өрөө, локерны асуудал шийдэгдээгүй байна.
2. Оюутны тоо хэт их, зарим оюутнуудыг хол эмнэлгүүдэд дадлагад гаргаж байгаа нь оюутнуудад хүндрэлтэй, дадлага удирдах гэрээт багш нар авч байгаа урамшуулалдаа сэтгэл дундуур, оюутны тоо их, ачаалал их зэрэг асуудлуудтай тулгарч байна.

Талархал: Танилцах дадлага хийх боломж, нөхцлөөр хангаж, АШУҮИС-ийн оюутнуудыг найрсаг хүлээн авч, эрүүл мэндийн мэргэжилтэн болох анхны гарааг

нь амжилттай тавихад байнга хамтран ажилладаг гэрээт эмнэлгүүд, тэдгээрийн удирдлага, дадлага удирдах гэрээт багш нартаа талархаж байна.

Ном зүй:

1. *С.Наранчимэг, С.Оюунцэцэг, С.Нармандах ба бусад, Чадварт суралцах нь, Улаанбаатар хот, 2020*
2. *https://www.aamc.org/media/23341/download*
3. *https://www.usnews.com/education/blogs/medical-school-admissions-doctor/articles/how-to-get-clinical-experience-as-a-pre-medical-student*
4. *Zhao Y, Cao Y, Che L, Fu Q, Song S, Zhao B, Zhang S, Zhang W, Li X, Choi S, Zhao J, Zhang H, Li Y, Xu H, Pan H. Ethical dilemma of identity disclosure faced by medical students in clinical clerkships: A nationwide multicenter study in China. PLoS One. 2018 Jul 11;13(7):e0200335. doi: 10.1371/journal.pone.0200335. PMID: 29995928; PMCID: PMC6040732.*
5. *Эрүүл мэндийн технологи, Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлүүд, MNS4621:2008, Улаанбаатар хот, 2008*
6. *Эрүүл мэндийн сайдын тушаал А/406, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, Улаанбаатар хот, 2019*
7. *Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS2023:7014, Улаанбаатар хот, 2023*
8. *Dickman N, Hijazi B, Samson AO, Even L. Tutors Matter: The Relationship between Medical Students' Satisfaction from Their Tutor and Their Overall Satisfaction from Clinical Rotations. International Medical Education. 2023; 2(3):124-130. https://doi.org/10.3390/ime 2030012*
9. *AkbariRad M, Khadem-Rezaiyan M, Ravanshad S, Rafiee M, Firoozi A, Zolfaghari SA, Aghaei HR, Zadehahmad R, Azarkar S, Moodi Ghalibaf A. Early clinical exposure as a highly interesting educational program for undergraduate medical students: an interventional study. BMC Med Educ. 2023 May 1;23(1):292. doi: 10.1186/s12909-023-04244-x. PMID: 37127647; PMCID: PMC10150660.*
10. *Theobald M, Rutter A, Steiner BD. A Bonus, Not a Burden: How Medical Students Can Add Value to Your Practice. Fam Pract Manag. 2021 Sep-Oct;28(5):5A-5C. PMID: 34519470.*
11. *Davis JM, Anderson MC, Stankevitz KA, Manley AR. Providing premedical students with quality clinical and research experience: the Tobacco Science Scholars Program. WMJ. 2013 Oct;112(5):195-8. PMID: 24734413; PMCID: PMC4023636.*
12. *Alsiö Å, Wennström B, Landström B, Silén C. Implementing clinical education of medical students in hospital communities: experiences of healthcare professionals. Int J Med Educ. 2019 Mar 27;10:54-61. doi: 10.5116/ijme.5c83.cb08. PMID: 30927541; PMCID: PMC6773366*

Some results of introductory practice of the second year premedical and prehealth students

Uzmee M[1], Narmandakh S[1], Enkhtuguldur M[2], Bolormaa O[1], Oyuntsetseg S[1]

[1]Department of Communication skills, School of Bio-medicine,MNUMS
[2]Department of Epidemiology and Biostatistics, School of Public health, MNUMS
E-mail: uzmee@mnums.edu.mn, Tel: +976-90091108

Background: It is important to acquire the required knowledge, skills, and attitudes which can be performed sincerely and responsibly by applying knowledge based on science, comprehensively practicing the student's knowledge, skills and attitudes in the medical environment, creating impressions for the first step to work in the hospital, demonstrating the comprehensive competence of manual skills at the basic medical training level, establishing relationships and acting with sincere heart whenever providing care to clients. Introductory practice is conducted in close coordination with contract teacher from the department, therefore there is increasing demand to listen to their opinions, problems, recommendations, study their satisfaction, and to make changes in the content and methodology of the program. It is necessary to study how effective and satisfactory was the introductory practice (96 hours, premedical) and (48 hours, prehealth) among students, and to improve the introductory practice furthermore.

Aim: To study the results of introductory practice of the premedical and prehealth students

Material and Methods: The study was performed using quantitative and qualitative research methods, along with hospital based observational design. Among 21 contract teachers from 16 different hospitals, who were approved by Division for undergraduate educational policy and management, 8 contract teachers agreed to participate in the study and they were asked to answer questionnaire including 5 closed, 2 open questions using google form. Total of 162 students from premedical and prehealth training, were asked to answer questionnaire including 7 closed, 2 open questions using google form. Participants were asked to rate each satisfaction indicator on a 1-5 scale (1-very poor, 5- very good) using a five-point Likert scale to determine satisfaction. Furthermore, conducted a one-on-one interview with 8 contract teachers using a sheet with guided question.

Results: 37.5% of the contract teachers of the department answered that they had moderate difficulty, 25% answered they had little difficulty, and 37.5% answered they had very little difficulty to practice students alongside with work in the hospital. 60% of the contract teachers rated the initial knowledge and skills of the students as moderate and 40% rated as good. Students were mostly satisfied with the communication and attitude of hospitals' doctors and nurses and 82.4% of the students rated it as good or very good. 75.5% of the students rated the communication and attitude of the customers receiving health care from the hospital as good or very good. Moreover, also 75.5% of the students rated the communication and attitude of other health proffesionals working at hospital as good or very good. Majority of the students, 81.7% rated that introductory practice was effective.

Conclusions:

1. Introductory practice is the first step of clinical practice for medical and health students, in other words important practice which allows students to apply and use the content of the course. However, the issue of study rooms, changing rooms and lockers for students in hospitals has not been resolved.
2. There are several problems, such as the number of students is too high, some students are being sent to practice in distant hospitals, which causes difficulties for the students, the contract teachers who manage the practice are dissatified with the bonuses they receive, and they are facing with large number of students and heavy workload.

Keywords: Satisfaction, Learning environment, Competence, Demand